ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** САГ-2026/247/НА-СТА-ТШЗ


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаанбаатар хот<br>2026 он | Санхүүгийн аудитын газрын захирал,<br>тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг<br>Утас:51-261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Энхдалай<br>Утас:51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn<br>Ахлах аудитор: А.Даваадорж<br>Утас: 51-261628 Цахим хаяг: davaadorja@audit.gov.mn<br>Аудитор: М.Ганбаатар<br>Утас: 51- 261628 Цахим хаяг: Ganbaatar.m@audit.gov.mn |


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 2
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 12
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 15
4. АУДИТЫН ТАЙЛАН ..... 18
4.1 Ерөнхий зүйл ..... 18
4.2 Материаллаг байдал ..... 18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... 19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 20
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 20
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... 20
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 21
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 22
5.1 Төлбөрийн акт ..... 22
5.2 Албан шаардлага ..... 23
5.3 Зөвлөмж ..... 25
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 26


**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АМГТГ | Ашигт малтмал газрын тосны газар |
| УСНББОУС | Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт |
| МУЗГ | Монгол Улсын Засгийн газар |
| ҮГА | Үндэсний геологийн алба |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2026.02.24 № 06/273

танай ____________-ны №____________-т

ҮНДЭСНИЙ ГЕОЛОГИЙН АЛБАНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Н.МӨНХБИЛЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үндэсний геологийн албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 43,202,482.7 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа болон нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны 41,204,279.9 мянган төгрөгийн 21 ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй гэрээг эцэслэн дүгнээгүй, урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй;
- Санхүүгийн тайланд 1,483,606.0 мянган төгрөгийн хөрөнгийг зөв ангилаагүй, бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй;
- Тайлант хугацаанд байгууллага нь ажиллагчидтай холбоотой 12,601.4 мянган төгрөгийн авлага, мөн бараа, ажил, үйлчилгээний зардлаас үүдэлтэй 49,695.4 мянган төгрөгийн өглөгийг үүсгэсэн;
- Төсвийг зохистой удирдаагүй 8,270.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулалттай зэрэг зөрчлүүд байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6, 16 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5, 6, 13, 14, 20 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, иж бүрэн байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг**

Тайлант онд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын А/154 тоот тушаалын дагуу 285,000.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 515,471.0 мянган төгрөгийн серверийн компьютер, тоног төхөөрөмж үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Мөн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны 303 дугаар тогтоолоор үнийг шинэчлэн тогтоож 197,204.0 мянган төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгасан байна.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Үндэсний геологийн алба нь Геологийн баримтын төв архиваас судалгааны тайлан уншлага, тайлан хэвлэх, хувилах, гео мэдээллийн төвөөс мэдээлэл боловсруулах үйлчилгээ үзүүлэн нийт 310,629.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Улсын төсвийн хөрөнгөөр 2020-2025 онд 91,738.94 км.кв талбайд хэрэгжиж буй 6 төслийн үр дүнг хүлээн авч, Монгол Улсын эрдэс баялгийн мэдээллийн санд бүртгүүлж, Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 48.6 хувийг хамруулсан байна.

Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын газрын хэвлийн ашиглалтын хамтарсан дэд комиссын I, II хуралдаан протоколыг үндэслэсэн Монгол Улсад Олон Улсын геологийн олимпиадыг 2025 оны 06 дугаар сард зохион байгуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 101,131,952,778.49 | 112,518,872,392.68 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 17,846,711,335.65 | 17,920,058,661.09 |
| 31200 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 17,846,711,335.65 | 17,920,058,661.09 |
| 31210 | Төгрөг | 17,846,711,335.65 | 17,920,058,661.09 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 17,846,711,335.65 | 17,920,058,661.09 |
| 33 | АВЛАГА | 16,726,050.25 | 89,320,663.45 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | - | 7,047,543.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | - | 76,719,205.46 |
| 33500 | Бусад авлага | 16,726,050.25 | 5,553,914.99 |
| 33510 | Байгууллагаас авах авлага | 16,726,050.25 | 5,553,914.99 |
| 34 | УРЬДЧИЛГАА | 83,123,336,288.41 | 94,318,844,266.96 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | 83,043,114,288.41 | 94,318,844,266.96 |
| 34710 | Урьдчилгаа тооцоо | 80,222,000.00 | - |
| 34711 | Бараа материал бэлтгэх урьдчилгаа | 51,770,000.00 | - |
| 34714 | Томилолтын урьдчилгаа | 28,452,000.00 | - |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 145,179,104.18 | 190,648,801.18 |
| 35400 | Хангамжийн материал | 145,179,104.18 | 190,648,801.18 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,149,500.00 | 4,207,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 46,758,641.39 | 100,024,616.39 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 2,579,478.00 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 92,691,484.79 | 86,416,684.79 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 132,984,666,231.05 | 137,022,929,196.80 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 132,984,666,231.05 | 137,022,929,196.80 |
| 39200 | Биет хөрөнгө | 2,411,586,957.02 | 2,925,438,936.12 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 2,319,344,356.41 | 2,319,344,356.41 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (888,370,590.93) | (929,730,994.53) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 162,200,000.00 | 547,200,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (148,866,666.72) | (164,075,000.07) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж(компьютер) | 1,898,356,112.37 | 2,488,265,460.11 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (1,151,445,883.33) | (1,524,941,297.15) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 353,177,596.80 | 352,543,896.80 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (204,233,244.65) | (232,453,938.68) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 83,381,741.38 | 83,381,741.38 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (11,956,464.31) | (14,095,288.15) |
| 39300 | Биет бус хөрөнгө | 130,573,079,274.03 | 134,097,490,260.68 |
| 39301 | Програм хангамж | 291,676,140.00 | 291,676,140.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (235,372,380.00) | (271,764,500.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 130,516,775,514.03 | 134,109,553,229.03 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | - | (31,974,608.35) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 234,116,619,009.54 | 249,541,801,589.48 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,457,462,308.75 | 2,482,899,434.10 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,457,462,308.75 | 2,482,899,434.10 |
| 41300 | Өглөг | 2,457,462,308.75 | 2,482,899,434.10 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 2,358,075.35 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 17,213,740.00 | 17,213,740.00 |
| 41360 | Бусад өглөг | 2,440,248,568.75 | 2,463,327,618.75 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 2,440,248,568.75 | 2,463,327,618.75 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 231,659,156,700.79 | 247,058,902,155.38 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 231,659,156,700.79 | 247,058,902,155.38 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 21,299,375.00 | 21,299,375.00 |
| 511001 | Улсын төсвийн оруулсан хөрөнгө | 21,299,375.00 | 21,299,375.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 231,637,857,325.79 | 246,840,173,480.38 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 192,688,091,061.99 | 231,637,857,325.79 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 38,949,766,263.80 | 15,202,316,154.59 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | - | 197,429,300.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 234,116,619,009.54 | 249,541,801,589.48 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 42,810,011,802.56 | 18,407,837,973.57 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 734,210,074.00 | 18,407,837,973.57 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 734,210,074.00 | 1,103,663,856.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 734,210,074.00 | 321,952,400.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 289,266,779.00 | 310,629,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 444,943,295.00 | 11,322,500.00 |
| 120009 | Бусад орлого | - | 2,221,256.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | - | 779,490,200.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 17,304,174,117.57 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 17,304,174,117.57 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 16,957,015,337.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 16,957,015,337.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 326,177,948.57 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 150,341,672.21 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 175,836,276.36 |
| 122001 | Бусад хандив тусламж /дотоод/ | - | 20,980,832.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 42,075,801,728.56 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 41,707,218,167.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 41,707,218,167.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 368,583,561.56 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 307,673,109.76 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 60,910,451.80 | - |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,860,245,538.76 | 3,205,521,818.98 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,860,245,538.76 | 3,205,521,818.98 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,419,191,973.82 | 2,724,545,110.30 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,043,310,598.30 | 1,383,552,878.16 |
| 210101 | Үндсэн цалин | 588,842,474.28 | 862,961,608.86 |
| 210102 | Нэмэгдэл | 230,928,424.02 | 213,128,876.29 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 150,190,000.00 | 224,496,302.33 |
| 210104 | Урамшуулал | 73,349,700.00 | 82,966,090.68 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 132,443,215.00 | 78,581,239.37 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 87,662,811.58 | 51,596,459.99 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 10,558,761.06 | 6,357,631.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 9,197,818.26 | 6,075,065.70 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 5,004,764.85 | 2,910,416.60 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 20,019,059.25 | 11,641,666.08 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 23,873,512.41 | 31,426,550.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,927,471.54 | 16,728,023.34 |
| 210302 | Түлш, халаалт | 9,391,640.87 | 11,794,306.41 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,554,400.00 | 2,904,220.84 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 250,338,057.30 | 115,841,085.16 |
| 210401 | Бичиг хэрэг | 153,193,600.00 | 17,938,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,538,322.00 | 5,079,478.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 31,574,547.82 | 26,055,482.16 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,904,580.00 | 60,493,025.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 32,045,942.18 | 6,274,800.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 4,751,065.30 | - |
| 2105 | Нормативт зардал | 1,113,225.10 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,113,225.10 | - |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 234,506,931.00 | 64,810,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,653,970.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 231,852,961.00 | 64,810,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 150,300,325.00 | 70,935,862.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,300,325.00 | 70,935,862.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 757,781,440.13 | 413,201,513.77 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 685,965,075.13 | 383,993,773.77 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,982,950.00 | 5,108,970.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 307,915.00 | 450,545.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 31,100.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 64,045,900.00 | 23,217,605.00 |
| 210807 | Газрын төлбөр | 430,500.00 | 430,620.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,018,000.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 825,524,669.58 | 566,195,981.25 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 284,284,839.00 | 942,100.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,415,000.00 | 2,090,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 530,824,830.58 | 563,163,881.25 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 441,053,564.94 | 480,976,708.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,648,900.00 | 16,000,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,700,000.00 | 16,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,948,900.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 325,888,002.14 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,712,384.01 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 17,908,839.13 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 289,266,779.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 78,516,662.80 | 464,976,708.68 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 78,516,662.80 | 464,976,708.68 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 38,949,766,263.80 | 15,202,316,154.59 |
| VI | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 38,949,766,263.80 | 15,202,316,154.59 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 58,065,147,067.56 | 17,543,848,760.11 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 15,895,645,049.00 | 17,543,848,760.11 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 15,895,645,049.00 | 337,374,680.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 734,810,074.00 | 335,203,424.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 289,266,779.00 | 310,629,900.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 445,543,295.00 | 24,573,524.00 |
| 120009 | Бусад орлого | 15,160,834,975.00 | 2,171,256.00 |
| 122 | Тусламжийн орлого | - | 17,206,474,080.11 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | - | 17,206,474,080.11 |
| 12211 | Харъяа төрийн сангаас төсвийн байгууллагад олгосон санхүүжилт, шилжүүлгийн орлого | - | 16,957,015,337.00 |
| 122111 | Урсгал санхүүжилтийн орлого | - | 16,957,015,337.00 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | - | 249,458,743.11 |
| 122131 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 73,622,466.75 |
| 122135 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 175,836,276.36 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 42,169,502,018.56 | - |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 41,707,218,167.00 | - |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 41,707,218,167.00 | - |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 462,283,851.56 | - |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 307,673,109.76 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 154,610,741.80 | - |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,481,913,574.30 | 2,591,191,717.12 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,481,913,574.30 | 2,591,191,717.12 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,028,631,648.36 | 2,109,715,008.44 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,044,624,108.64 | 1,283,650,800.05 |
| 210101 | Үндсэн цалин | 559,251,415.14 | 718,751,757.48 |
| 210102 | Нэмэгдэл | 263,667,864.65 | 228,441,225.19 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 148,719,553.65 | 223,652,970.43 |
| 210104 | Урамшуулал | 72,985,275.20 | 112,804,846.95 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 131,860,800.00 | 159,165,400.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын зардал | 89,665,400.00 | 110,077,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын зардал | 10,548,900.00 | 12,272,100.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгалын зардал | 5,274,400.00 | 6,136,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын зардал | 5,274,500.00 | 6,136,000.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын зардал | 21,097,600.00 | 24,543,900.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 24,863,512.41 | 31,426,550.59 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,927,471.54 | 16,728,023.34 |
| 210302 | Түлш, халаалт | 10,381,640.87 | 11,794,306.41 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,554,400.00 | 2,904,220.84 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 208,375,327.82 | 44,481,168.83 |
| 210401 | Бичиг хэрэг | 139,956,500.00 | 7,397,800.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 22,996,000.00 | 2,500,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 31,574,547.82 | 21,974,818.83 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 330,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,518,280.00 | 12,608,550.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 234,506,931.00 | 72,018,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 5,280,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,653,970.00 | 588,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 231,852,961.00 | 66,150,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 150,300,325.00 | 80,282,905.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,300,325.00 | 80,282,905.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 898,281,804.49 | 391,262,383.97 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 826,465,439.49 | 358,438,730.64 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,982,950.00 | 5,108,970.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 307,915.00 | 450,545.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 31,100.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 64,045,900.00 | 26,563,518.33 |
| 210807 | Газрын төлбөр | 430,500.00 | 430,620.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,018,000.00 | 270,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 335,818,839.00 | 47,427,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 325,403,839.00 | 45,337,800.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 10,415,000.00 | 2,090,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 453,281,925.94 | 481,476,708.68 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 36,648,900.00 | 16,500,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 10,700,000.00 | 16,500,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 25,948,900.00 | - |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 325,888,002.14 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 18,712,384.01 | - |
| 213305 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 17,908,839.13 | - |
| 213306 | Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг | 289,266,779.00 | - |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 90,745,023.80 | 464,976,708.68 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 90,745,023.80 | 464,976,708.68 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 54,583,233,493.26 | 14,952,657,042.99 |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 39,787,747,776.12 | 14,879,309,717.55 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 39,787,747,776.12 | 14,879,309,717.55 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 39,787,747,776.12 | 14,879,309,717.55 |
| 223001 | Бусад хөрөнгө | 39,711,289,306.12 | 14,821,868,817.55 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 76,458,470.00 | 57,440,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (39,787,747,776.12) | (14,879,309,717.55) |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 14,795,485,717.14 | 73,347,325.44 |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 3,051,225,618.51 | 17,846,711,335.65 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 17,846,711,335.65 | 17,920,058,661.09 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,299,375.00 | - | 191,955,309,680.65 | 191,976,609,055.65 |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | 732,781,381.34 | 732,781,381.34 |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,299,375.00 | - | 192,688,091,061.99 | 192,709,390,436.99 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | - | - | 38,949,766,263.80 | 38,949,766,263.80 |
| 10 | 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 21,299,375.00 | - | 231,637,857,325.79 | 231,659,156,700.79 |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 21,299,375.00 | - | 231,637,857,325.79 | 231,659,156,700.79 |
| 14 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт | - | 197,429,300.00 | - | 197,429,300.00 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | - | - | 15,202,316,154.59 | 15,202,316,154.59 |
| 20 | 2025 оны 12-р сарын 31-нрх үлдэгдэл | 21,299,375.00 | 197,429,300.00 | 246,840,173,480.38 | 247,058,902,155.38 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 21,926,605,800.00 | 16,887,736,710.58 | 5,038,869,089.42 | 77.0 |
| 12 | Татварын бус орлого | 21,926,605,800.00 | 16,887,736,710.58 | 5,038,869,089.42 | 77.0 |
| 122 | Тусламжийн орлого | 21,926,605,800.00 | 16,887,736,710.58 | 5,038,869,089.42 | 77.0 |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 21,926,605,800.00 | 16,887,736,710.58 | 5,038,869,089.42 | 77.0 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 21,926,605,800.00 | 16,887,736,710.58 | 5,038,869,089.42 | 77.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,926,605,800.00 | 1,766,018,513.80 | 160,587,286.20 | 91.7 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,910,105,800.00 | 1,749,518,513.80 | 160,587,286.20 | 91.6 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,256,903,500.00 | 1,239,016,800.05 | 17,886,699.95 | 98.6 |
| 210101 | Үндсэн цалин | 705,721,900.00 | 674,117,757.48 | 31,604,142.52 | 95.5 |
| 210102 | Нэмэгдэл | 250,704,600.00 | 228,441,225.19 | 22,263,374.81 | 91.1 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 201,389,600.00 | 223,652,970.43 | (22,263,370.43) | 111.1 |
| 210104 | Урамшуулал | 99,087,400.00 | 112,804,846.95 | (13,717,446.95) | 113.8 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 153,399,400.00 | 153,399,400.00 | - | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 104,311,400.00 | 104,311,400.00 | - | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 12,272,100.00 | 12,272,100.00 | - | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 6,136,000.00 | 6,136,000.00 | - | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 6,136,000.00 | 6,136,000.00 | - | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 24,543,900.00 | 24,543,900.00 | - | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 82,271,900.00 | 31,426,550.59 | 50,845,349.41 | 38.2 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 61,822,300.00 | 16,728,023.34 | 45,094,276.66 | 27.1 |
| 210302 | Түлш, халаалт | 18,155,900.00 | 11,794,306.41 | 6,361,593.59 | 65.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,293,700.00 | 2,904,220.84 | (610,520.84) | 126.6 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 84,104,300.00 | 44,481,168.83 | 39,623,131.17 | 52.9 |
| 210401 | Бичиг хэрэг | 21,675,200.00 | 7,397,800.00 | 14,277,400.00 | 34.1 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,500,000.00 | 2,500,000.00 | - | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 41,212,600.00 | 21,974,818.83 | 19,237,781.17 | 53.3 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 752,800.00 | - | 752,800.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 17,963,700.00 | 12,608,550.00 | 5,355,150.00 | 70.2 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 76,372,100.00 | 74,658,000.00 | 1,714,100.00 | 97.8 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,280,000.00 | 5,280,000.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 4,942,100.00 | 3,228,000.00 | 1,714,100.00 | 65.3 |
| 210604 | Урсгал засвар | 66,150,000.00 | 66,150,000.00 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 7,327,400.00 | 7,327,381.00 | 19.00 | 100.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 7,327,400.00 | 7,327,381.00 | 19.00 | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 232,922,000.00 | 182,404,013.33 | 50,517,986.67 | 78.3 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 126,955,100.00 | 94,779,460.00 | 32,175,640.00 | 74.7 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 5,444,700.00 | 5,108,970.00 | 335,730.00 | 93.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 561,200.00 | 450,545.00 | 110,655.00 | 80.3 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 69,000.00 | - | 69,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 97,649,100.00 | 81,364,418.33 | 16,284,681.67 | 83.3 |
| 210807 | Газрын төлбөр | 449,900.00 | 430,620.00 | 19,280.00 | 95.7 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 1,793,000.00 | 270,000.00 | 1,523,000.00 | 15.1 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,805,200.00 | 16,805,200.00 | - | 100.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 14,715,200.00 | 14,715,200.00 | - | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,090,000.00 | 2,090,000.00 | - | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 16,500,000.00 | 16,500,000.00 | - | 100.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 16,500,000.00 | 16,500,000.00 | - | 100.0 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 16,500,000.00 | 16,500,000.00 | - | 100.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 20,000,000,000.00 | 15,121,718,196.78 | 4,878,281,803.22 | 75.6 |
| 223001 | Бусад хөрөнгө | 20,000,000,000.00 | 15,121,718,196.78 | 4,878,281,803.22 | 75.6 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 17,846,711,335.65 | (17,846,711,335.65) | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 17,920,058,661.09 | (17,920,058,661.09) | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1 | 1 | - | 100.0 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 | - | 100.0 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 32 | 32 | - | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15 | 15 | - | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 16 | 16 | - | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 24 | 24 | - | 100.0 |
| 650001 | Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 13 | 13 | - | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 11 | 11 | - | 100.0 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

*Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон*

*/төгрөгөөр/*

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | | 249,458,743.11 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | | 249,458,743.11 |
| 122 | Тусламжийн орлого | | 249,458,743.11 |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | | 249,458,743.11 |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 249,458,743.11 |
| 350011 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | 73,622,466.75 |
| 350015 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 175,836,276.36 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 164,390,560.85 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | | 164,390,560.85 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | | 164,390,560.85 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | | 44,634,000.00 |
| 210101 | Үндсэн цалин | | 44,634,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | | 5,766,000.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | | 5,766,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | 21,873,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | | 21,873,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 92,117,560.85 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 92,117,560.85 |
| 4 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | | 85,068,182.26 |
| 5 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | | (85,068,182.26) |
| 6 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | | (85,068,182.26) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | - |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | - |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үндэсний геологийн алба нь эрхэм зорилгоо “Геологийн шинжлэх ухаанд үндэслэсэн мэдээллээр дамжуулан үндэсний тогтвортой хөгжлийг хангана” гэж тодорхойлсон байна.

Үндэсний геологийн алба нь эрхэм зорилгын хүрээнд дараах үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Төрийн захиргааны удирдлагын манлайлал, хүний нөөцийн удирдлагаар хангах, байгууллагын хөрөнгө санхүүгийн эх үүсвэрийг оновчтой удирдах, тайлагнах, албаны үйл ажиллагаатай холбоотой дүрэм, журам, стандарт боловсруулах, батлуулах мөрдүүлэхэд эрх зүйн дэмжлэг үзүүлэх, салбарын хэмжээнд байгуулагдах гэрээ, хэлэлцээр хийх ажлыг зохион байгуулах, сурталчлах, хяналт-шинжилгээ үнэлгээний асуудлыг эрхлэх, гадаад орнууд олон улсын геологийн алба байгууллагатай хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Геологи, тектоник, стратиграфи, магматизм, тандан судлал, геоэкологи, гидрогеологи, грунт-геотехник, гео-гамшиг гэх зэрэг төрөл бүрийн сэдэвчилсэн судалгааны ажлын санал боловсруулах, судалгаа-шинжилгээ хийх, бүтээл хэвлүүлэх, улсын төсвийн хөрөнгөөр явуулах төслийг удирдан чиглүүлэх, геологийн шинжлэх ухаан үйлдвэрлэлийн хөгжлийн бодлогын санал зөвлөмж боловсруулах;
- Нутаг дэвсгэрийн хэмжээнд үнэт, өнгөт, хар, ховор, холимог металл, металл бус, шатах болон энергийн түүхий эд зэрэг төрөл бүрийн ашигт малтмалын чиглэлээр суурь судалгааны ажлыг төлөвлөх, эрхлэх, минерагений судалгаа, шинжилгээ хийх бүх шатны эрлийн ажлыг гүйцэтгэж эрдэс баялгийн хэтийн төлөвийг тодорхойлох, геологи-үйлдвэрлэлийн төлөвлөлт, бүтээл хэвлүүлэх, бусад төсөл гүйцэтгэгчийг удирдлагаар хангах, эрдэс баялгийн бодлогын санал, зөвлөмж боловсруулах, ашигт малтмалын улсын нэгдсэн бүртгэл хөтлөх, нөөцийн хөдөлгөөнийг бүртгэх, нөөцийн тэнцэл гаргах;
- Суурь болон сэдэвчилсэн судалгааны ажлуудын төлөвлөлтийг эдийн засгийн үндэслэлтэй хийх нөхцөлийг бүрдүүлж үнэлгээний суурь түвшнийг тогтоох, геологи-эдийн засгийн үнэлгээ, харьцуулсан судалгааг явуулж, тогтмол шинэчлэн боловсруулах;
- Геологи, эрдэс баялгийн салбарын мэдээллийн төрөлжсөн, нэгдсэн сан бүрдүүлэх баяжуулах, боловсруулах, хэрэглэгчийг хуулиар хориглоогүй мэдээллээр хангах;
- Геологи, эрдэс баялгийн салбарын хэвлэмэл болон цахим баримт материалыг Газрын хэвлийн тухай хууль, Архивын тухай хуулийн дагуу хадгалах, хамгаалах, нөхөн бүрдүүлэх, ашиглах, нэгдсэн тайлан мэдээлэл гаргах;

Үндэсний геологийн алба нь 1992 онд улсын төсөвт үйлдвэрийн газар хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байгаад 1994 оноос Эрчим хүч, геологи, уул уурхайн яаманд Геологийн газрын нэгж, 1996 оноос Ашигт малтмал, газрын тосны газрын нэгжийн бүтцэд багтан Геологийн алба, Геологийн газар, Геологи, хайгуулын хэлтэс хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байсан.

Үндэсний геологийн албаны даргын 2025 оны А/55 даргын тушаалаар бүтэц орон тоо, албан тушаалын нэршлийг шинэчлэн 6 хэлтэс 32 орон тоотойгоор баталсан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Ашигт малтмалын тухай хууль, Газрын тосны тухай хууль, Газрын хэвлийн тухай хууль, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох дүрэм, журмуудыг мөрдлөг болгон ажиллаж байна.

Тайлант хугацаанд тус газрын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна.

- Төсвийн тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналт, хариуцлагын тогтолцоог чангатгаж, төсвийн сахилга бат, дунд хугацааны тогтвортой байдлыг хангахад чиглэсэн. Тухайлбал, төсвийг зохисгүй удирдсанаас авлага, өглөг үүсгэсэн төсвийн захирагчид хариуцлага тооцох эрх зүйн үндсийг тодорхой болгож, дунд хугацааны төсвийн мэдээлэлд хараат бус хяналтыг нэмэгдүүлсэн, мөн төсвийн баримт бичгийн хугацааг богиносгон зохион байгуулалтын сахилга батыг сайжруулсан. Түүнчлэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс үл хамааран төсвийн бодлогын залгамж чанарыг хадгалах, эрх мэдлийн давхардлыг арилгах зохицуулалтыг тусгаснаар төсвийн эрсдэлийг бууруулж, санхүүгийн удирдлагын хяналтын орчныг бэхжүүлсэн;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь төрийн байгууллагын үйл ажиллагааны зардлыг хязгаарлах, хэмнэлтийг бодитоор хэрэгжүүлэхэд чиглэсэн. Үүнд, зөвлөл, хороо, ажлын хэсгийн гишүүдэд нэмэлт хөлс, урамшуулал олгохыг хориглож, байгууллагын төсвөөр уралдаан, арга хэмжээ зохион байгуулах, семинар, хурал, томилолттой холбоотой зардлыг бууруулах, мөн албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах замаар бичиг хэргийн болон шуудангийн зардлыг хэмнэх зохицуулалтыг хуульчилсан;
- Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд 2025 онд орсон нэмэлт, өөрчлөлтүүд нь дунд хугацааны төсвийн хүрээ, нэгдсэн төсвийн тэнцвэржилт, төсвийн тодотголын зохицуулалтыг бодит нөхцөлд нийцүүлэн уян хатан болгох, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүний өөрчлөлтөөс шалтгаалан төсвийн тогтвортой байдлын шалгуур зөрчигдөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн. Мөн төсвийн тогтвортой байдлын үзүүлэлт, тайлагналтай холбоотой зарим давхардсан заалтыг цэгцэлж, эрх зүйн зохицуулалтыг оновчтой болгосон;
- Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ыг шинэчлэн баталж, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын нэгдмэл, стандартчилагдсан хэрэгжилтийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Тайлант онд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын зарим байгууллагын ажлыг сайжруулах, эрчимжүүлэх, хүнд суртлыг бууруулж, бүтээмжийг нэмэгдүүлэх, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах зорилгоор Үндэсний геологийн албаны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Үндэсний геологийн алба нь 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллага нь Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа бөгөөд үүнд геологийн судалгааны ажлын техник хяналтын зардлын бүртгэлд баримтлах бодлогыг тусгаагүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үндэсний геологийн алба нь 2025 оны санхүүгийн тайланг хүчингүй болсон Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэн Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын хоёрдугаар хавсралтын дагуу тайланг баталгаажуууллаа.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 15,425,182.6 мянган төгрөгөөр буюу 6.5 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 17,846,711.3 | 17,920,058.7 | 73,347.3 |
| Авлага | 16,726.1 | 89,320.7 | 72,594.6 |
| Урьдчилгаа | 83,123,336.3 | 94,318,844.3 | 11,195,508.0 |
| Бараа материал | 145,179.1 | 190,648.8 | 45,469.7 |
| Үндсэн хөрөнгө | 132,984,666.2 | 137,022,929.2 | 4,038,263.0 |
| **Нийт хөрөнгө** | **234,116,619.0** | **249,541,801.6** | **15,425,182.6** |
| Өр төлбөр | 2,457,462.3 | 2,482,899.4 | 25,437.1 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 231,659,156.7 | 247,058,902.2 | 15,399,745.5 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **234,116,619.0** | **249,541,801.6** | **15,425,182.6** |

*Эх сурвалж: Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл*

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 73,347.3 мянган төгрөгөөр нэмэгдэхэд техник хяналт аргачлалын зардал дансны үлдэгдэл 71,176.0 мянган төгрөгөөр өссөн;
- Авлага дансны үлдэгдэл 89,320.7 мянган төгрөг болж өсөхөд БНСУ-ын геологийн судалгааны байгууллага “Кигам” төслийн санхүүжүүлсэн төслийн зарцуулаагүй үлдэгдэл 76,719.2 мянган төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн;
- Урьдчилгаа данс нь 11,195,508.9 мянган төгрөгөөр өсөхөд тайланд онд 16 геологи судалгааны ажлын санхүүжилтийг бүртгэсэн;
- Бараа материал данс 45,469.7 мянган төгрөгөөр өсөхөд аж ахуйн материалд 70,570.0 мянган төгрөгийн геологийн толь бичиг худалдан авсан;
- Үндсэн хөрөнгө данс 137,022,929.2 мянган төгрөг болж өсөхөд Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын А/154 тоот тушаалаар 800,471.0 мянган төгрөгийн автомашин болон серверийн тоног төхөөрөмж үнэ төлбөргүй шилжиж ирсэн, мөн геологи судалгааны 3 төслийн 3,592,777.7 мянган төгрөгийг урьдчилж гарсан зардлаас биет бус хөрөнгөд шилжүүлэн бүртгэсэнтэй холбоотой;
- Биет бус хөрөнгийн дансанд 275.0 мянган төгрөгийн 1 санхүүгийн программ хангамж, 107,583.0 мянган төгрөгийн 4 лиценз бүртгэлтэй.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс урсгал зардалд 2,128,056.0 мянган төгрөг, хөрөнгийн зардалд 40,000,000.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 42,128,056.0 мянган төгрөгийг зарцуулахаар тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч ирүүлсэн төсвийн төслийн саналаас урсгал зардлыг 132,050.1 мянган төгрөгөөр 1,996,005.9 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 20,000,000.0 мянган төгрөгөөр бууруулж , нийт зардлыг 21,996,005.9 мянган төгрөгөөр баталсан байна.

Урсгал зардлаас байр ашиглалттай холбоотой зардлыг 16,732.5 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 35,905.1 мянган төгрөгөөр, албан томилолтын зардлыг 25,000.0 мянган төгрөг, эд хогшил урсгал засварыг 7,350.0 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 10,545.8 төгрөгөөр, бусад зардлыг 36,525.7 мянган төгрөгөөр тус тус бууруулсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль 2025 оны 07 дугаар сарын 09-ний өдөр батлагдсантай холбогдуулан бараа, ажил, үйлчилгээний зардлыг 169,923.5 мянган төгрөгөөр бууруулж, нийт зардлыг 21,826,082.40 мянган төгрөгөөр баталсан байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх олборлолт, уул уурхай /70905/ хөтөлбөрийн хүрээнд 8 арга хэмжээг санхүүжүүлэхээр, батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс 16,957,015.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, 16,887,736.7 мянган төгрөгийг зарцуулан, 69,278.6 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 16,887,736.7 мянган төгрөг буюу 77.0 хувьтай байгаа нь төсвийн хүндрэлтэй байдлаас шалтгаалж геологи хайгуул, судалгаа, шинжилгээний зардал 4,878,281.81 мянган төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны зардал нийлээд 128,411.65 мянган төгрөгөөр, байр ашиглалт, тогтмол зардал 31,629.00 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2.* Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагааны зардал | 1,783,150.7 | 1,654,739.1 | 128,411.7 | 92.8 |
| 2 | Мэдээлэл сурталчилгааны зардал | 2,430.3 | 2,430.3 | 0.1 | 100.0 |
| 3 | Харуул, хамгаалалтын зардал | 59,224.0 | 58,680.0 | 544.0 | 99.1 |
| 4 | Байр ашиглалтын үйлчилгээ | 60,979.0 | 29,350.0 | 31,629.0 | 48.1 |
| 5 | Ажил олгогчоос олгох тэтгэмж, | 1,500.0 | 1,500.0 | - | 100.0 |
| 6 | Эмчилгээний төлбөр | 15,000.0 | 15,000.0 | - | 100.0 |
| 7 | Геологи хайгуул, судалгаа | 20,000,000.0 | 15,121,718.2 | 4,878,281.8 | 75.6 |
| 8 | Химийн хорт бодисыг хоргүйжүүлэх | 4,320.2 | 4,319.2 | 1.0 | 100.0 |
| | **Нийт дүн** | **21,926,604.2** | **16,887,736.7** | **5,038,867.5** | **77.0** |

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагаас судалгаа авч, үр дүнг тусгалаа. Үүнд:

- Тайлант онд Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлсэн 9 хувийн цомхотголтой холбоотойгоор 35 орон тооноос 3 орон тоо хасаж 32 болгон бууруулж бүтэц орон тоогоо шинэчлэн баталсан ;
- Үндэсний геологийн албаны даргын 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн А/17 дугаар тушаалаар ажилтнуудад олгох хоол, унааны хөнгөлөлтийн хэмжээг баталж, нэг ажилтанд ногдох хоолны хөнгөлөлтийг 32.0 мянган төгрөг, унааны хөнгөлөлтийг 3.0 мянган төгрөгөөр тогтоосон;
- Аж үйлдвэр эрдэс баялгийн сайдын 2025 оны А/42 дүгээр тушаалын дагуу албаны даргын үүргийг түр гүйцэтгэгч П.Батцацрал нь БНСУ-ын Сөүл хотноо Монгол-Солонгосын ховор металлын хамтын ажиллагааны Хамтарсан хорооны 2 дугаар хуралдаанд оролцож 5,792.8 мянган төгрөгийн гадаад томилолтын зардал гаргасан байна. Монгол Улсын болон Бүгд Найрамдах Солонгос Улсын Засгийн газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд Геологи судалгаа шинжилгээний төвийн дэргэд ховор металлын төв ашиглалтад орсон;

- Тайлант онд Төрийн худалдан авах ажиллагааны газрын А3 сертификаттай сургалт 1 албан хаагч хамрагдаж 90.0 мянган төгрөг, "Чой Лувсанжав" хэл иргэншлийн эрдмийн хүрээлэнтэй байгуулсан 25/18 дугаартай гэрээний дагуу нийт ажилтнуудыг хамруулсан сургалтын үйлчилгээ авч 1,500.0 мянган төгрөг, Архивын ерөнхий газрын мэргэшүүлэх сургалтад 2 албан хаагч хамрагдаж 500.0 мянган төгрөгийн зардлыг тус тус гаргасан;
- Үндсэн чиглэлийн судалгаагаар одоо ашиглагдахгүй 1 санхүүгийн программ хангамж, 4 лиценз бүртгэлтэй;
- Төрд учирсан хохиролтой холбоотой зардал гараагүй, хэвлэл мэдээллийн байгууллагатай гэрээ хэлцэл хийгээгүй байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн сан дахь Үндэсний геологийн албаны нэмэлт санхүүжилтийн 100900018410 тоот дансанд нийт 249,4586.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдсэнээс, 164,390.6 мянган төгрөгийг зарцуулж, 85,068.2 мянган төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Улсын төсвийн орлого

Үндэсний геологийн алба нь 2025 онд улсын төсөвт 120,000.0 мянган төгрөгийн геологи, эрдэс баялгийн мэдээлэл технологийн, архив лавлагааны орлого төвлөрүүлэхээр төсвийн төслийг тооцон дээд шатны төсөв захирагчид хүргүүлснийг дүнгээр нь баталсан байна.

Улсын төсвийн орлогын гүйцэтгэл 310,629.9 мянган төгрөг буюу 158.9 хувиар давж биелсэн нь тухайн орлогын онцлог болон өмнөх оны гүйцэтгэлтэй уялдуулж бодитой төлөвлөж, батлуулаагүйтэй холбоотой байна.

### 3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайдын 2024 оны А/108 дугаар тушаалын хавсралтаар Үндэсний геологийн албаны 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталсан бөгөөд урсгал болон улсын төсвийн хөрөнгөөр нийт 18,731,694.9 мянган төгрөгийн 11 нэр бүхий бараа, ажил, үйлчилгээ худалдан авахаар тусгасан байна.

Гүйцэтгэлээр 18,396,516.6 мянган төгрөгийн геологийн судалгаа шинжилгээний ажлын 16 багц худалдан авалтад нээлттэй тендер шалгаруулалт, 246,106.9 мянган төгрөгийн 5 худалдан авалтад харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт явуулж гэрээ байгуулсан. Босго үнийн дүнгээс бага нийт 28,725.5 мянган төгрөгийн 5 шууд худалдан авалт хийсэн байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Үндэсний геологийн албаны 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Үндэсний геологийн алба түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор А.Даваадорж, аудитор М.Ганбаатар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Үндэсний геологийн алба 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 02/65 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2024 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, суурь үзүүлэлтийг нийт зарлагын дүнгээс сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 3,860,245.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 38,602.4 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзэв.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан хуулиар хориглосон гар утасны зардал, хэвлэл захиалгын төлбөр, зочин төлөөлөгч хүлээн авах зэрэг арга хэмжээг төлөвлөгдөөгүй учраас санхүүжүүлээгүй байна.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн асуудалд 4 зөвлөмж өглөө.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд горим сорил хэрэгжүүлэхэд шилэн дансны нэгдсэн системд мэдээллийг бүрэн байршуулсан тул Шилэн дансны тухай хуультай нийцсэн, бусад хууль, тогтоомжийн заалтуудтай нийцээгүй гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

*1.Илрүүлэлт:* Тус байгууллага 2024–2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж баталсан боловч уг баримт бичиг нь салбарын нэгдсэн бодлого, эрх зүйн суурьгүй нөхцөлд хэрэгжиж байгаа нь хөгжлийн бодлогын уялдаа, хариуцлагын тогтолцоог бүрэн хангаж чадахгүй байна.

Тухайлбал:

- Геологийн салбарын нэгдсэн бодлого байхгүй “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” (2021) хүчингүй болсон бөгөөд орлох шинэ бодлого батлагдаагүй байна.
- Стратеги төлөвлөгөө нь төрийн хөгжлийн баримт бичгүүдийг формаль буюу нэр томьёоны түвшинд уялдуулсан ч, уялдааны бодит хэрэгжилт, хэмжүүр, хариуцлага, үнэлгээний тогтолцоо бүрдээгүй — Төлөвлөгөөнд “Алсын хараа–2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдсан гэж заасан ч эдгээр бодлогын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг Үндэсний геологийн албаны стратегийн зорилтуудтай холбох тоон болон чанарын үзүүлэлт, хяналт-шинжилгээний аргачлал, тайлагналын бүтэц тусгагдаагүй байна.
- Хөгжлийн бодлогын (нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх) зарчмыг хангаж чадаагүй.
- Геомэдээллийн нэгдсэн бодлого, мэдээллийн стандарт, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй.

Энэ нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3-т "Агентлагийн дарга нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.3.1-д энэ хуулийн 7.1.1-д заасан хууль тогтоомж, зарлиг, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, явц, биелэлтэд хяналт тавих" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Байгууллагын стратеги төлөвлөгөөтэй уялдуулан салбарын нэгдсэн бодлогын баримт бичгийг боловсруулан, мөрдөж ажиллах зөвлөмж өгсөн.

*2. Илрүүлэлт:* Тус байгууллагын сүүлийн 3 жилийн улсын төсвийн орлогын төлөвлөгөө 110,000.0–130,000.0 мянган төгрөгөөр батлагдсан боловч гүйцэтгэл 310,629.9–734,810.0 мянган төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 2.6–5.6 дахин давсан байна. Энэ нь орлогыг бодит бус, дутуу төлөвлөж, төсвийн санал, тооцоог үндэслэлгүйгээр боловсруулж хүргүүлснийг харуулж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй" гэж заасантай нийцэхгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Улсын төсвийн орлогын төлөвлөлтийг бодит гүйцэтгэл, өмнөх жилүүдийн орлогын өсөлт, бууралтын чиг хандлага, эдийн засгийн нөхцөл байдалд үндэслэн нарийвчилсан тооцоо, судалгаатайгаар боловсруулж, төсвийн санал, тооцооны үндэслэлийг холбогдох баримт бичгээр баталгаажуулан, бодитой, үндэслэлтэй төлөвлөх арга хэмжээ авах зөвлөмж өгсөн.

*3. Илрүүлэлт:* Үндэсний геологийн албаны бүтэц орон тооны хязгаарыг 2020 оноос хойш нийт 3 удаа өөрчилж, орон тооны хязгаарыг 47.0 хувиар бууруулсан, мөн сүүлийн 3 жилийн дунджаар Үндэсний геологийн албаны албан хаагчдын 68.7 хувь буюу давхардсан тоогоор 67 албан хаагч томилогдох, чөлөөлөгдөх, шилжин ажиллах зэргээр хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнд орсноор тухай байгууллагын үйл ажиллагаа тогтвортой, хэвийн тасралтгүй явагдах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхүйц байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан "тогтвортой байх" зарчмыг алдагдуулсан байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д Төрийн албанд Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмаас гадна дараах зарчмыг баримтална: 7.1.2-т мэргэшсэн, тогтвортой байх" гэж заасантай нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Хүний нөөцийг тогтвортой ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах зөвлөмж өгсөн.

*4.Илрүүлэлт*: Төрөлжсөн архив нь Үндэсний геологийн албанаас тусдаа байранд буюу АМГТГ-ын 1 дүгээр давхарт сан хөмрөг, уншлага, үйлчилгээний танхим бүхий байранд байрлаж байгаа бөгөөд сан хөмрөгийн фондын өрөө, тасалгааны хананд цууралт өгч, шал нь зарим хэсгээр цөмөрсөн, зориулалтын бус, агаар чийгшүүлэгч байхгүй архивд хадгалагдаж байгаа 10813 тайлан, 98907 хадгаламжийн нэгжийг хадгалах өрөө тасалгааны талбайн хэмжээ бага байна.

Энэ нь Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1-д Архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд дараах зарчмыг баримтална: 3.1.4-т хадгалалт, хамгаалалт аюулгүй, найдвартай байх; 26.3.1-д.архивын зориулалтын байр, тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх; 26.3.3-т архивын аюулгүй байдлын баталгааг хангасан, баримтын хадгалалт, хамгаалалтын тохиромжтой нөхцөлийг бүрдүүлсэн байх; 29.6-д Архивын баримтыг зориулалтын байранд холбогдох журам, стандартын дагуу тавиур, шүүгээнд хадгална" гэж заасантай тус тус нийцээгүй байна.

*Шийдвэрлэсэн нь:* Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар шалгагдагч байгууллагын 2025 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланг хамруулан, мөнгөн хөрөнгө, цалингийн зардал, бараа материал болон үндсэн хөрөнгийн данстад аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Аудитын үр дүнд нийт 89,046,879.7 мянган төгрөгийн дүн бүхий 18 алдаа, зөрчил илэрсэн бөгөөд эдгээр асуудлын хэрэгжилт, залруулгын байдлыг жилийн эцсийн аудитаар дахин хянан шалгаж, үр дүнг аудитын тайланд тусгасан.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх онд тус албаны санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн хэрэгжүүлж, аудитаар илэрсэн зөрчлөөс 1,571,795.7 мянган төгрөгийн зөрчилд хүргүүлсэн 5 албан шаардлага 100. хувь, 1,829,943.9 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 9 зөвлөмжөөс 1,442,018.9 мянган төгрөгийн 8 зөвлөмжийг хэрэгжүүлж 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

*Хүснэгт 4.* Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

*/мянган төгрөгөөр/*

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Албан шаардлага | 5 | 1,571,795.7 | 5 | 1,571,795.7 | 100.0 |
| зөвлөмж | 9 | 1,829,943.9 | 8 | 1,442,018.9 | 98.0 |
| **Нийт дүн** | **14** | **3,401,739.6** | **13** | **3,013,814.6** | **99.0** |

Өмнөх оны аудитаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн ажлын техник хяналтын зардлын бүртгэлийг холбогдох журам, зохицуулалтын хүрээнд боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Түүнчлэн тайлант онд хэрэгжиж дууссан геологийн ажлуудыг биет бус хөрөнгөөр орлого хүлээн зөвшөөрөхдөө өмнөх онуудад гарсан техник хяналтын 379,621.8 мянган төгрөгийг тухайн тайлант оны зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тоот журмын 4.Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэнтэй нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, геологийн ажлын техник хяналтын зардлын бүртгэлийг холбогдох хууль, журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад нийцүүлэн боловсруулаагүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлсэн.

## 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар дараах асуудлуудыг авч үзэх нь зүйтэй байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн газрын 2018 оны 371 дүгээр тогтоолоор Дорноговь аймгийн Улаанбадрах суманд орших Зөөвч-Овоо ордын ашиглалтын MV-018915 дугаартай тусгай зөвшөөрөл эзэмшигч Бадрах энержи ХХК нь ураны ордын технологийн туршилттай холбогдуулан байгаль орчныг хамгаалах, цөмийн болон цацрагийн ослоос сэргийлэх баталгаа болгон 900,000.0 ам.доллартой тэнцэх мөнгөн хөрөнгийг Төрийн сангийн холбогдох дансанд байршуулахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамд даалгасан гэвч байгууллагын чиг үүрэгт хамааралгүй уг хөрөнгийг Үндэсний геологийн албаны санхүүгийн тайланд 2,433,204.0 мянган төгрөгийг барьцаа хөрөнгийн өглөгөөр тусгасан;
- Үндэсний геологийн албаны жил бүрийн төсөв, судалгааны ажлын төлөвлөгөө нь стратегийн түвшинд батлагдсан бодлого, хөтөлбөртэй уялдаагүй, зөвхөн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүжилтийн хүрээнд төлөвлөгддөг;
- Үндэсний геологийн албаны төрийн захиргааны албан тушаалын үндсэн орон тоонд хамаарах нийт 32 албан тушаалтан нь төрийн албан хаагчийн шалгалт өгч, тангараг өргөөгүй түр томилготой, 5 албан хаагчийг тусгай шалгалт явуулалгүйгээр албан тушаалд томилсон байна. /удирдах түвшний 2, гүйцэтгэх түвшний 3/ Тухайлбал: Тус байгууллагын сүүлийн 2 агентлагийн дарга нь албан үүргийг түр орлон гүйцэтгэгч томилготой байжээ.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар УСНББОУС 19, 23, 25 дугаар заалттай нийцээгүй нийт 80,770.8 мянган төгрөгийн 4 алдаа илэрснээс 80,770.8 мянган төгрөгийн 4 алдааг аудитын явцад залруулллаа.

***Залруулсан алдаа:***

- Геологи судалгааны ажлын гэрээний хугацаа хэтэрсэнтэй холбоотой 2,171.2 мянган төгрөгийн хугацааны алдангийн бичилтийг өглөгөөр буруу бүртгэсэн;
- Тайлант онд нэр бүхий ажилтанд 491.0 мянган төгрөгийг илүү олгосон цалинг буцаан төлүүлсэнтэй холбоотойгоор авлагаар бүртгэсэн;
- Нэг албан хаагчийн ээлжийн амралтын тооцоог 1,389.4 мянган төгрөгийн зөрүүтэй тооцоолж бүртгэлд тусгасан;
- Нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэлтэй КИГАМ төслийн зарцуулаагүй 79,719.2 мянган төгрөгийн үлдэгдлийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй орхигдсоныг тус тус нягтлан бодох бүртгэлд залруулан бүртгүүлсэн.

Аудитаар нийт 43,202,482.7 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс, 8,270.0 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 41,710,606.7 мянган төгрөгийн зөрчилд 7 албан шаардлага хүргүүлж, 1,483,606.0 мянган төгрөгийн зөрчилд 6 зөвлөмж өгсөн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 43,202,482.7 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 43,163,880.3 мянган төгрөгөөр давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

1. Хээрийн материал хүлээн авах албан томилолтын хүрээнд анхан шатны баримтаар нотлогдоогүй 6,930.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*”, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь*</u>: Анхан шатны нотлох баримтгүй шатахууны зардлыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Тус байгууллагын тооцооны нягтлан бодогчид 2025 оны 5 дугаар сард байгууллагын даргын зохих тушаал, шийдвэргүйгээр 100 хувийн үр дүнгийн урамшуулал тооцон 1,340.0 мянган төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Тушаал шийдвэр, хууль журмыг зөрчин илүү тооцож олгосон үр дүнгийн урамшууллыг улсын төсөвт буцаан төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**5.2 Албан шаардлага**

1. Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 02 дугаар тушаалын дагуу Хэнтий аймгийн 7 сум, Дорнод аймгийн 4 суманд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцах, хяналт шалгалт хийх, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөхөд 4,370.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг гаргасан байна. Энэ нь Үндэсний геологийн албаны хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэгт хамаарахгүй бөгөөд анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд байгууллага нь ажиллагчидтай холбоотой 12,601.5 мянган төгрөгийн авлага, мөн бараа, ажил, үйлчилгээний зардлаас үүдэлтэй 49,695.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Төсвийн удирдлага, гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байгаагаас санхүүгийн сахилга бат алдагдаж, авлага, өр төлбөрийн үлдэгдэл бодитой тусгагдахгүй байх, улмаар санхүүгийн тайлангийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

3. Авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Жолоочийн тооцооны хуудас хөтлөөгүй, шатахуун зарцуулалтын тайлан тооцоог хянаагүй зарлага гаргасан, мөн автомашин ашиглах эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл ашигласны улмаас 5,079.5 мянган төгрөгийн зардал гаргасан байна.
- Үндэсний геологийн алба нь туулах чадвар сайтай Land Cruiser 200, Land Cruiser 300, мөн 25 хүний суудалтай бага оврын автобусыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэйгээр эзэмшиж байгаа боловч Засгийн газрын автобазаас автомашин түрээсэлж, шаардлагагүйгээр 37,380.3 мянган төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.1 "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

<u>*Шийдвэрлэсэн нь:*</u> Байгууллага өөрийн данс бүртгэлд байгаа тээврийн хэрэгслийг ашиглахдаа шатахуун зарцуулалтын тооцоог тогтмол хийх, мөн өөрт байгаа нөөц бололцоогоо ашиглах илүү зардал гаргахгүй байх зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

4. Техник хяналтын зардлын данснаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй оффисын хөшиг худалдан авч 6,500.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга

хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

_Шийдвэрлэсэн нь_: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй бараа, ажил үйлчилгээ худалдан авалт хийдэг, техник хяналтын зардлыг зориулалт зөрчин зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож албан шаардлага хүргүүлэв.

5. Урьдчилж гарсан зардлын дансанд “Геологийн санхүүжилт /ҮГАлба/” нэршлээр 856.7 мянган төгрөг, Авай медиа ХХК-тай холбоотой 5,000.0 мянган төгрөг, Ард даатгал ХК-тай холбоотой 4,936.6 мянган төгрөг, Эйбл софт ХХК-тай холбоотой 285.0 мянган төгрөгийн санхүүжилт бүртгэлтэй боловч эдгээр нь гэрээ, хэлцэл болон холбогдох бусад анхан шатны баримтаар баталгаажихгүй байна. Энэ нь санхүүгийн бүртгэлийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно*.”, 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

_Шийдвэрлэсэн нь:_ Урьдчилж гарсан зардалд байгаа санхүүжилтийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, гэрээг дүгнээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

6. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байсны улмаас 21 төслийн гэрээний гүйцэтгэлийг эцэслэн дүгнээгүй, урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 41,204,279.9 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд зөв ангилан бүртгээгүй, дотоод хяналтын үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлээгүй, мөн уг чиг үүргийг хариуцсан мэргэжилтэн бүтэц, орон тоонд тусгагдаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.2-т бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага"; 20 дугаар зүйлийн 20.2.6-д “*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах*”, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 4.1.12 дахь заалттай тус тус нийцээгүй байна.

_Шийдвэрлэсэн нь:_ Урьдчилж гарсан зардлын дансанд хуримтлуулан бүртгэсэн 41,204,279.9 мянган төгрөгийн геологийн судалгааны ажлын үр дүнг эцэслэн дүгнээгүй, биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй зөрчлийг арилгах зөрчлийг арилгах албан хүргүүлэв.

**5.3 Зөвлөмж**

1. Бараа материалын данстай холбоотой

Тайлант онд байгууллага нь ашиглалтын хугацаа нэг жилээс дээш хугацаатай ашиглаж буй нийт 11,067.5 мянган төгрөгийн өртөг бүхий дрон 1 ширхэг, цахилгаан үүсгүүр 1 ширхэг, зам заагч төхөөрөмж 3 ширхэг, принтер 1 ширхэг, архивын саарал тавиур 20 ширхэг, хар махир хөлтэй сандал 29 ширхэг эд хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцээгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж</u>*: Бараа материалын дансанд буруу ангилан бүртгэсэн эд хөрөнгийг үндсэн хөрөнгийн ангилалд шилжүүлж, нягтлан бодох бүртгэлийг засварлан залруулах;

2. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой

*<u>Илрүүлэлт</u>:* Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглаж байгаа 275 ширхэг 1,472,538.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцээгүй байна.

*<u>Өгсөн зөвлөмж:</u>* Ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглаж байгаа үндсэн хөрөнгийн ашиглалтын байдлыг тогтоож, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэж ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### 6.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

| № | Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Геологи судалгааны ажлын гэрээний хугацаа хэтэрсэнтэй холбоотойгоор өглөгөөр буруу бүртгэсэн 2,171.2 мянган төгрөгийн хугацааны алдангийн бичилтийг залруулсан | 1 | 2,171.26 | | | 1 | 2,171.26 | 1 | 2,171.26 | | | | |
| 2 | Тайлант онд нэр бүхий ажилтанд илүү олгосон цалинг буцаан төлүүлсэнтэй холбоотойгоор авлагаар бүртгэсэн бичилтийг залруулж, зохих дансанд дахин бүртгэсэн. | 1 | 491.00 | | | 1 | 491.00 | 1 | 491.00 | | | | |
| 3 | Нэг албан хаагчийн ээлжийн амралтын тооцоог зөрүүтэй тооцоолж бүртгэлд тусгасныг залруулсан. | 1 | 1,389.40 | | | 1 | 1,389.40 | 1 | 1,389.40 | | | | |
| 4 | Нэмэлт санхүүжилтийн дансанд бүртгэлтэй КИГАМ төслийн зарцуулаагүй үлдэгдлийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгээгүй орхигдсоныг залруулж, нягтлан бодох бүртгэлд зөвөөр тусгуулсан. | 1 | 76,719.20 | | | 1 | 76,719.20 | 1 | 76,719.20 | | | | |
| | **Дүн** | **4** | **80,770.86** | | | **4** | **80,770.86** | **4** | **80,770.86** | | | | |

## 6.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны | Тоо | Дүн |
| 1 | Хээрийн материал хүлээн авах томилолтын хүрээнд анхан шатны нотлох баримтаар нотлогдоогүй 6,930.0 мянган төгрөгийн шатахууны зардал гаргасан байна. | 1 | 6,930.0 | 1 | 6,930.0 | | | | | | | | |
| 2 | Тус байгууллагын тооцооны нягтлан бодогч нь 2025 оны 5 дугаар сард байгууллагын даргын зохих тушаал, шийдвэргүйгээр өөртөө 100 хувийн үр дүнгийн урамшуулал тооцон 1,340.0 мянган төгрөгийг хууль, журмын үндэслэлгүйгээр авсан байна" | 1 | 1,340.0 | 1 | 1,340.0 | | | | | | | | |
| 3 | Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 02 дугаар тушаалын дагуу Хэнтий аймгийн 7 сум, Дорнод аймгийн 4 суманд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцах, хяналт шалгалт хийх, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөхөд 4,370.0 мянган төгрөгийн томилолтын зардлыг гаргасан байна. Энэ нь Үндэсний геологийн албаны хууль тогтоомжоор олгогдсон чиг үүрэгт хамаарахгүй бөгөөд анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. | 1 | 4,370.0 | | | 1 | 4,370.0 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 4 | Тайлант хугацаанд байгууллага нь ажиллагчидтай холбоотой 12,601.4 мянган төгрөгийн авлага, мөн бараа, ажил, үйлчилгээний зардлаас үүдэлтэй 49,695.4 мянган төгрөгийн өглөгийг үүсгэсэн байна. Төсвийн удирдлага, гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байгаагаас санхүүгийн сахилга бат алдагдаж, авлага, өр төлбөрийн үлдэгдэл бодитой тусгагдахгүй байх, улмаар санхүүгийн тайлангийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болсон байна. | 1 | 62,296.8 | | | 1 | 62,296.8 | | | | | | |
| 5 | Техник хяналтын зардлын данснаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй оффисын хөшиг худалдан авч 6,500.0 мянган төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна. | 1 | 6,500.0 | | | 1 | 6,500.0 | | | | | | |
| 6 | Авто тээврийн хэрэгслийн ашиглалттай холбоотой дараах зөрчил илэрлээ. Үүнд:<br>• Шатахуун зарцуулалтын бүртгэл, хяналт хангалтгүй байна. Тодруулбал, жолоочийн замын хуудас хөтлөгдөөгүй, шатахуун зарцуулалтын тайлан, тооцоог нягтлан бодогч гаргадаггүй, шатахууны талоныг бөөн дүнгээр зарлага гаргасан, мөн автомашин ашиглах эрхгүй этгээд тээврийн хэрэгсэл ашигласны улмаас 5,079.5 мянган төгрөгийн зардал гаргасан байна.<br>• Үндэсний геологийн алба нь туулах чадвар сайтай Land Cruiser 200, Land Cruiser 300, мөн 25 хүний суудалтай бага оврын автобусыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэйгээр эзэмшиж байгаа боловч Засгийн газрын автобазаас автомашин түрээсэлж, шаардлагагүйгээр 37,380.3 мянган төгрөгийн нэмэлт зардал гаргасан байна. | 1 | 42,459.8 | | | 1 | 42,459.8 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Өмнөх оны аудитаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн ажлын техник хяналтын зардлын бүртгэлийг холбогдох журам, зохицуулалтын хүрээнд боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Түүнчлэн тайлант онд хэрэгжиж дууссан геологийн ажлуудыг биет бус хөрөнгөөр орлого хүлээн зөвшөөрөхдөө өмнөх онуудад гарсан техник хяналтын 379,621.8 мянган төгрөгийг тухайн тайлант оны зардлаар бүртгэсэн байна. | 1 | 379,621.8 | | | 1 | 379,621.8 | | | | | | |
| 8 | Урьдчилж гарсан зардлын дансанд “Геологийн санхүүжилт /ҮГАлба/” нэршлээр 856.7 мянган төгрөг, Авай медиа ХХК-тай холбоотой 5,000.0 мянган төгрөг, Ард даатгал ХК-тай холбоотой 4,936.6 мянган төгрөг, Эйбл софт ХХК-тай холбоотой 285.0 мянган төгрөгийн санхүүжилт бүртгэлтэй боловч эдгээр нь гэрээ, хэлцэл болон холбогдох бусад анхан шатны баримтаар баталгаажихгүй байна. Энэ нь санхүүгийн бүртгэлийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсгэж байна. | 1 | 11,078.4 | | | 1 | 11,078.4 | | | | | | |
| 9 | Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байсны улмаас 35 төслийн гэрээний гүйцэтгэлийг эцэслэн дүгнээгүй, урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 68,673,830.7 мянган төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд зөв ангилан бүртгээгүй, дотоод хяналтын үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлээгүй, мөн уг чиг үүргийг хариуцсан мэргэжилтэн бүтэц, орон тоонд тусгагдаагүй байна. | 1 | 41,204,279.9 | | | 1 | 41,204,279.9 | | | | | | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 10 | Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй ашиглалтын хугацаа дуусаж, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн боловч ашиглагдаж байгаа 275 ширхэг 1,472,538.5 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй, ашиглах хугацаа, үнийг шинэчлэн тогтоох саналыг ТӨБЗГ-т хүргүүлж, шийдвэрлүүлээгүй байна. | 1 | 1,472,538.5 | | | | | 1 | 1,472,538.5 | | | | |
| 11 | Тайлант онд байгууллага нь ашиглалтын хугацаа нэг жилээс дээш, үйл ажиллагаанд давтан ашиглагдаж буй нийт 11,067.5 мянган төгрөгийн өртөг бүхий дрон 1 ширхэг, цахилгаан үүсгүүр 1 ширхэг, зам заагч төхөөрөмж 3 ширхэг, принтер 1 ширхэг, архивын саарал тавиур 20 ширхэг, хар махир хөлтэй сандал 29 ширхэг эд хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн байна. | 1 | 11,067.5 | | | | | 1 | 11,067.5 | | | | |
| | **Дүн** | **11** | **43,202,482.7** | **2** | **8,270.0** | **7** | **41,710,606.7** | **2** | **1,483,606.0** | **0** | **0** | **0** | **0** |

## 6.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

| № | Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| 1 | Тус байгууллага 2024–2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулж баталсан боловч уг баримт бичиг нь салбарын нэгдсэн бодлого, эрх зүйн суурьгүй нөхцөлд хэрэгжиж байгаа нь хөгжлийн бодлогын уялдаа, хариуцлагын тогтолцоог бүрэн хангаж чадахгүй байна.<br>Тухайлбал:<br>- Геологийн салбарын нэгдсэн бодлого байхгүй — “Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлого” (2021) хүчингүй болсон бөгөөд орлох шинэ бодлого батлагдаагүй байна.<br>- Стратеги төлөвлөгөө нь төрийн хөгжлийн баримт бичгүүдийг формаль буюу нэр томьёоны түвшинд уялдуулсан ч, уялдааны бодит хэрэгжилт, хэмжүүр, хариуцлага, үнэлгээний тогтолцоо бүрдээгүй — Төлөвлөгөөнд “Алсын хараа–2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Засгийн газрын 2024–2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-тэй уялдсан гэж заасан ч эдгээр бодлогын зорилго, зорилт, шалгуур үзүүлэлтийг Үндэсний геологийн албаны стратегийн зорилтуудтай холбох тоон болон чанарын үзүүлэлт, хяналт-шинжилгээний аргачлал, тайлагналын бүтэц тусгагдаагүй байна.<br>- Хөгжлийн бодлогын (нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх) зарчмыг хангаж чадаагүй.<br>- Геомэдээллийн нэгдсэн бодлого, мэдээллийн стандарт, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй. | 1 | - | | | | | 1 | - |
| 2 | Тус байгууллагын сүүлийн 3 жилийн улсын төсвийн орлогын төлөвлөгөө 110,000.0–130,000.0 мянган төгрөгөөр батлагдсан боловч гүйцэтгэл 310,629.9–734,810.0 мянган төгрөгт хүрч, төлөвлөгөөнөөс 2.6–5.6 дахин давсан байна. Энэ нь орлогыг бодит бус, дутуу төлөвлөж, төсвийн санал, тооцоог үндэслэлгүйгээр боловсруулж хүргүүлснийг харуулж байна. | 1 | - | | | | | 1 | - |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | Үндэсний геологийн албаны бүтэц орон тооны хязгаарыг 2020 оноос хойш нийт 3 удаа өөрчилж, орон тооны хязгаарыг 47.0 хувиар бууруулсан, мөн сүүлийн 3 жилийн дундажаар ҮГА-ны албан хаагчдын 68.7 хувь буюу давхардсан тоогоор 67 албан хаагч томилогдох, чөлөөлөгдөх, шилжин ажиллах зэргээр хүний нөөцийн шилжилт хөдөлгөөнд орсноор тухай байгуулагын үйл ажиллагаа тогтвортой, хэвийн тасралтгүй явагдах, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхүйц байгаа нь Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т заасан "тогтвортой байх" зарчмыг алдагдуулсан байна. | 1 | - | | | | | 1 | - |
| 4 | Төрөлжсөн архив нь Үндэсний геологийн албанаас тусдаа байранд буюу АМГТГ-ын 1 дүгээр давхарт сан хөмрөг, уншлага, үйлчилгээний танхим бүхий байранд байрлаж байгаа бөгөөд сан хөмрөгийн фондын өрөө, тасалгааны хананд цууралт өгч, шал нь зарим хэсгээр цөмөрсөн, зориулалтын бус, агаар чигшүүлэгч байхгүй архивд хадгалагдаж байгаа 10813 тайлан, 98907 хадгаламжийн нэгжийг хадгалах өрөө тасалгааны талбайн хэмжээ бага байна. | 1 | - | | | | | 1 | - |
| | **Дүн** | **4** | | | | | | **4** | **-** |

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АКТ**

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 04/А0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын тооцооны нягтлан бодогчид 2025 оны 5 дугаар сард байгууллагын даргын зохих тушаал, шийдвэргүйгээр 100 хувийн үр дүнгийн урамшуулал тооцон 1,340,000.00 /нэг сая гурван зуун дөчин мянган /төгрөгийг олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*”, 13.7-д “*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 “*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*”-ын 4.2.3.3-д “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон” гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тушаал шийдвэргүйгээр олгосон 1,340,000.00 /нэг сая гурван зуун дөчин мянган/ төгрөгийг Б.Уугансаягаар төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч /Ц.Эрдэнэ-очир / нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Akt\2026\0224 SAG-1.Docx

1526200013

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АКТ**

2026 оны 02 сарын 24 өдөр | Дугаар 05/А0170081 | Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШЗ

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хээрийн материал хүлээн авах албан томилолтын хүрээнд анхан шатны баримтаар нотлогдоогүй 6,930,000.00 /зургаан сая есөн зуун гучин мянган / төгрөгийн шатахууны зардал гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*", Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно*", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.3.6-д "эрх бүхий этгээдээс тогтоосон норм, нормативыг хэтрүүлэн зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Шатахууны зардалд олгосон, анхан шатны баримтаар нотлогдоогүй 6,930,000.00 /зургаан сая есөн зуун гучин мянган/ төгрөгийг Н.Мөнхбилэгээр төлүүлж Үндэсний аудитын газрын Төрийн сан банкин дахь аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч /Ц.Эрдэнэ-очир/ нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР — Ц.НАРАНЧИМЭГ

АУДИТЫН МЕНЕЖЕР — Д.ЭНХДАЛАЙ

АУДИТОР — М.ГАНБААТАР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Akt\2026 0224 SAG-1.Docx

1526200007

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 17/А0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

- Шатахуун зарцуулалтын бүртгэл, хяналт хангалтгүй байна. Тодруулбал, жолоочийн замын хуудас хөтлөгдөөгүй, шатахуун зарцуулалтын тайлан, тооцоог нягтлан бодогч гаргадаггүй, шатахууны талоныг бөөн дүнгээр 5,079,478.00 /Таван сая далан есөн мянга дөрвөн зуун далан найман/ төгрөгийн зардал гаргасан;
- Үндэсний геологийн алба нь туулах чадвар сайтай Land Cruiser 200, Land Cruiser 300, мөн 25 хүний суудалтай бага оврын автобусыг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэйгээр эзэмшиж байгаа боловч Засгийн газрын автобазаас автомашин түрээслэж, шаардлагагүйгээр 37,380,333.00 /гучин долоон сая гурван зуун наян мянга гурван зуун гучин гурван / төгрөгийн нэмэлт зардал гаргасан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” 16 дугаар зүйлийн 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 16.5.6-д “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” 41 дүгээр зүйлийн 41.2.2-т "батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно” гэснийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*”-ын 4.2.1.1 “нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтлөж, баталгаажуулаагүй” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Байгууллага өөрийн данс бүртгэлд байгаа тээврийн хэрэгслийг ашиглахдаа замын хуудас, шатахуун зарцуулалтын тооцоог тогтмол хийх, өөрийн авто тээврийн хэрэгслийг ашиглаж, илүү зардал гаргадаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

9005109
АТА16037
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 18/А0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн ажлын техник хяналтын зардлын бүртгэлийг холбогдох журам, зохицуулалтын хүрээнд боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна. Түүнчлэн тайлант онд хэрэгжиж дууссан геологийн ажлуудыг биет бус хөрөнгөөр орлого хүлээн зөвшөөрөхдөө өмнөх онуудад гарсан техник хяналтын 379,621,877.23 / гурван зуун далан есөн сая зургаан зуун харин мянга найман зуун далан долоон / төгрөгийг тухайн тайлант оны зардлаар бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1. "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: 5.1.3.жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4.үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4. "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.1.аж ахуйн бүх ажил, гүйлгээ; 14.4.2.бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 18 дугаар зүйлийн 18.1. "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ" гэснийг хэрэгжүүлээгүй ажиллаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тоот журмын 4.Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэнтэй нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын үндэслэл 4.2.1.10 "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

1. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, геологийн ажлын техник хяналтын зардлын бүртгэлийг холбогдох хууль, журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгоогүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

9006109
АТА16037

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 19/А0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй геологийн судалгааны ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байсны улмаас 21 төслийн гэрээний гүйцэтгэлийг эцэслэн дүгнээгүй, урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 41,204,279,998.00 /дөчин нэгэн тэрбум хоёр зуун дөрвөн сая хоёр зуун далан есөн мянга есөн зуун ерэн найман/ төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлтэй нь уялдуулан биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч, санхүүгийн тайланд зөв ангилан бүртгээгүй, дотоод хяналтын үйл ажиллагааг зохих түвшинд хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:" 14.4.2-т "бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "*эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;*", Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А/87 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Улсын төсвийн хөрөнгөөр гүйцэтгэх геологийн судалгааны ажлыг санхүүжүүлэх, гүйцэтгэх, үр дүнг тооцох журам"-ын 4.1.12 дахь заалттай нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.1-т "нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй;" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилж гарсан зардлын дансанд бүртгэлтэй 41,204,279,998.00 /дөчин нэгэн тэрбум хоёр зуун дөрвөн сая хоёр зуун далан есөн мянга есөн зуун ерэн найман/ төгрөгийн эцэслэн дүгнээгүй 21 төслийн гэрээний санхүүжилтийг биет бус хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-1.Docx

15?618??62

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 20/A017-0081 Улаанбаатар хот

САГ-2026/247/ИА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Урьдчилж гарсан зардлын дансанд "Геологийн санхүүжилт /ҮГАлба/" нэршлээр 856,782.00 /найман зуун тавин зургаан мянга долоон зуун хоёр/ төгрөг, Авай медиа ХХК-тай холбоотой 5,000,000.00 /таван сая / төгрөг, Ард даатгал ХК-тай холбоотой 4,936,656.00 /дөрвөн сая есөн зуун гучин зургаан мянга зургаан зуун тавин зургаан/ төгрөг, Эйбл софт ХХК-тай холбоотой 285,000,00 /хоёр зуун наян таван мянган / төгрөгийн санхүүжилт бүртгэлтэй боловч анхан шатны баримтаар баталгаажаагүй байна. Энэ нь санхүүгийн бүртгэлийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх, улмаар төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүсгэж байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.*", 13.7-д "*Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.*", 20 дугаар зүйлийн 20.1.4-т "хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх", 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4 4.2.1.1.нягтлан бодох бүртгэлийн холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Урьдчилж гарсан зардалд байгаа санхүүжилтийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, гэрээг дүгнээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-1.Docx

15[illegible]6180060

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 21/А0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШЗ

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Техник хяналтын зардлын данснаас худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй оффисын хөшиг худалдан авч 6,500,000.00 /зургаан сая таван зуун мянган/ төгрөгийн зориулалт бус зардал гаргасан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 "Захиалагч батлагдсан төсөвт туссан төсөл, арга хэмжээ бүрээр худалдан авах ажиллагааг үр ашигтай төлөвлөж, батална", гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.6.төсвийг зориулалт бусаар зарцуулсан; гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдаагүй худалдан авалт хийдэг, зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

*Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-1.Docx*

1526180058

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 22/A0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд байгууллага нь ажиллагчидтай холбоотой 12,601,457.99 /арван хоёр сая зургаан зуун нэг мянга, дөрвөн зуун тавин долоон/ төгрөгийн авлага, мөн бараа, ажил, үйлчилгээний зардлаас үүдэлтэй 49,695,434.10 /Дөчин есөн сая зургаан зуун ерэн таван мянга, дөрвөн зуун гучин дөрвөн/ төгрөгийн өглөгийг үүсгэсэн байна. Төсвийн удирдлага, гүйцэтгэлийн хяналт хангалтгүй байгаагаас санхүүгийн сахилга бат алдагдаж, авлага, өр төлбөрийн үлдэгдэл бодитой тусгагдахгүй байх, улмаар санхүүгийн тайлангийн найдвартай байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэл бий болсон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;"гэсэнтэй нийцээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.5-д "төсвийн орлого, зарлагыг буруу тооцоолсон, төсөвт зардлыг хэтрүүлсэн" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зохистой удирдаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*



1576180054

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 24 өдөр Дугаар 23/А0170081 Улаанбаатар хот

САГ-2026/247/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Үндэсний геологийн албаны 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төрийн албаны зөвлөлийн даргын 2025 оны 02 дугаар тушаалын дагуу Хэнтий аймгийн 7 сум, Дорнод аймгийн 4 суманд Төрийн албаны тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, хүний нөөцийн зохицуулалтын хэрэгжилттэй танилцах, хяналт шалгалт хийх, албан хаагчдад төрийн албаны шинэтгэлийн талаар мэдээлэл, сургалт зохион байгуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөхөд 4,370,000.00 /Дөрвөн сая гурван зуун далан/ мянган төгрөгийн томилолтын зардлыг гаргасан байна. Энэ нь Үндэсний геологийн албаны хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүрэгт хамаарахгүй бөгөөд анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"; 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэснийг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "*Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам*"-ын 4.2.1.6-д "төсвийг зориулалт бусаар зарцуулсан" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийг зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Үндэсний геологийн албаны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Н.Мөнхбилэг/, ахлах нягтлан бодогч / Ц.Эрдэнэ-очир / нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРАНЧИМЭГ
АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ЭНХДАЛАЙ
АУДИТОР М.ГАНБААТАР

*Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230*

Z:\Alban Shaardlaga\2026\0124 SAG-1.Docx

1526180052